

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн, “Налайхын дулааны станц” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь**:

1. Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Налайх дүүргийн төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй компани, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 381 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	946.0
		Төг/ГДж	28,394.0
2	Төсвийн байгууллагын халаалт	Төг/м ³	1,419.0
		Төг/ГДж	37,044.0
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	5,955.0
		Төг/м ³	5,940.0

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф		
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	660.0		
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	3,163.0
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	4,425.0
		Усны зарцуулалтаар	Төг/м ³	5,500.0	
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.0		
3.2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.0		
3.3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0		